**ХЭНТИЙ АЙМАГ**
**БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 14 өдөр Дугаар А/12 Бор-Өндөр

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын 3.1 дэх хэсэг, Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 1.3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын хэмжээнд хийгдэж буй иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | |
| Б.Оюунтуяа | Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга: | |
| Б.Цогзолмаа | Холбоо 2 дугаар багийн зохион байгуулагч |
| Гишүүд: | |
| Б.Идэрбаяр | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч |
| Ч.Саруулмөнх | Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга |
| П.Энхцэцэг | Эд хөрөнгийн Улсын бүртгэгч |
| Э.Оюунням | Иргэний Улсын бүртгэгч |
| У.Дөлгөөн-Учрал | Бор-Өндөр 1 дүгээр багийн Зохион байгуулагч |
| Э.Номин | Бумбат 3 дугаар багийн Зохион байгуулагч |
| Э.Гуамарал | Хүйх 5 дугаар зохион байгуулагч |
| Д.Мөнгөнтуяа | Өлгий 6 дугаар багийн Зохион байгуулагч |
| Ц.Ганмягмар | Иргэний төлөөлөл |

2. Бор-Өндөр суманд шилжин ирж буй болон түр оршин суугч иргэний Улсын бүртгэлд хяналт тавьж эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын үр дүн цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг илтгэх хуудсаар сумын Засаг даргад 2025

оны 02 дугаар сарын 17-ны өдөр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

3. Хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээллэж ажиллахыг сумын Засаг даргын хэвлэл мэдээллийн ажилтан (Ш.Цэрэндолгор)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.АДЪЯАБИЛЭГТ